



**“ЖАВХЛАНТ ОРД”ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС  
СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ  
“ЗАНГАТ УУЛЫН ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ”  
ТӨСЛИЙН 2024 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-016952  
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5217652**

**БОЛОВСРУУЛСАН:**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН:**

**Б. НАСАНЖАРГАЛ**

## АГУУЛГА

|                                                                                                                                |     |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ ..                                                                | 3   |
| НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....                                                                                            | 4   |
| 1.1 Төслийн байршил.....                                                                                                       | 4   |
| 1.2 Төслийн хүчин чадал, ажлын горим .....                                                                                     | 6   |
| ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ЭРЧИМ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА .....                                                 | 7   |
| 2.1 Төсөл хэрэгжих үеийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим .....                     | 7   |
| 2.2 Төслийн талбай орчмын уур амьсгалын нөхцлийн суурь мэдээлэл .....                                                          | 9   |
| 2.3 Агаарын чанар.....                                                                                                         | 10  |
| 2.4 Гадаргын ус суурь мэдээлэл .....                                                                                           | 11  |
| 2.5 Ургамлан нөмрөгийн суурь мэдээлэл .....                                                                                    | 15  |
| 2.6 Амьтны аймаг суурь мэдээлэл.....                                                                                           | 17  |
| 2.7 Түүх соёлын дурсгал, авран хамгаалах ажлын суурь мэдээлэл .....                                                            | 19  |
| ГУРАВ. УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ. ....                                                 | 21  |
| ДӨРӨВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                                   | 23  |
| 4.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....                                             | 23  |
| 4.1.1 Агаарын чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө .....                                 | 23  |
| 4.1.2 Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах .....                                              | 99  |
| 4.1.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .....                                         | 121 |
| 4.1.4 Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах .....                                                                  | 143 |
| 4.1.5 Ургамалын зүйлийн бүрдэл ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын биелэлт .....                       | 161 |
| 4.1.6 Амьтан аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын биелэлт .....                                      | 164 |
| 4.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....                                                                               | 167 |
| 4.3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ .....                                                | 167 |
| 4.4 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ , НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                         | 186 |
| 4.5 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                                     | 186 |
| 4.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....                                                                     | 186 |
| 4.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....                                                                        | 205 |
| 4.8 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... | 236 |
| 4.9 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ..... | 244 |

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот дугаар тушаал “БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ”, “Байгаль орчныг хамгаалах тухай” “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан зэргийг удирдлага болгож боловсруулав.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тооцох, бууруулах, түүнд шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, хэрэгжүүлэх үе шат зэргийг нарийвчлан тусгах эрх зүйн бичиг баримт бөгөөд “Зангат уул” төслийн ажлыг үргэлжлүүлэх, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх (зам барих ) гэх мэт үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан арга хэмжээнүүдийг шат дараатай төлөвлөж хэрэгжүүлэх, төслийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт хийгдэх ажил, холбогдох төрийн байгууллага, сум орон нутгийн оролцогч талуудын санал дүгнэлтэнд үндэслэн боловсруулах зорилго тавин дараах байдлаар төлөвлөлөө.

Төлөвлөгөөт онд байгаль орчны хамгааллын чиглэлээр дараахь гол зорилтуудыг дэвшүүлсэн болно. байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг боломжит хамгийн бага хэмжээнд хүргэх зорилт тавьж байна Үүнд:

- Байгаль орчны бүх хууль, тогтоомжуудыг мөрдөж ажиллах
- Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны бүрдэл хэсгүүдэд нөлөөлөх
- Байгаль орчныг хамгаалах шилдэг аргуудыг үйл ажиллагаандаа бий болгох удирдлагын системийг хэрэгжүүлэх.
- Бүхий л үйл ажиллагаандаа "багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах" зарчмыг хэрэгжүүлэх.
- Ажилчдад байгаль орчноо хамгаалах хариуцлага, танин мэдэхүйг дээшлүүлэх, төслийн талбайд мөрдөгддөг журмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд сургалтанд хамруулах.
- Байгаль орчныг хамгаалах өөрсдийн үүрэг хариуцлагаа ухамсарлаж, үйлчлүүлэгч болон ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллах.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөлт хэрэгжилтийг тогтмол сайжруулах.
- Ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжийн хүрээнд мөрдөгддөг хууль тогтоомжыг хэрэгжүүлэх.
- Компанийн дотоод дүрэм, журам, горимд байгаль орчныг хамгаалах зорилгыг хэрэгжүүлэх заалтуудыг нэмэгдүүлэх.
- Нийт ажиллагсад, гэрээт олборлогч, ажилчид, ханган нийлүүлэгчид, сонирхогч талуудад байгаль орчны баримтлах бодлого, зорилгыг таниулах, уурхайд мөрдөх журмуудыг мөрдүүлэх
- Байгаль орчны бүх хууль, тогтоомжуудыг мөрдөж ажиллах
- Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны бүрдэл хэсгүүдэд нөлөөлөх

**НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА****Ерөнхий мэдээлэл:**

|                                                     |                                                                                                                                                                       |
|-----------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Төслийн нэр:                                        | ■ “Зангат-Уулын чулуун нүүрсний орд”-ыг ил аргаар ашиглах төсөл                                                                                                       |
| Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр: | ■ “Жавхлант орд” ХХК<br>- Улсын бүртгэлийн дугаар: 9019058049<br>- Регистрийн дугаар: 5217652                                                                         |
| Аж ахуй нэгжийн албан ёсны хаяг, утас               | ■ Хаяг: Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 26, Их хуралдай бизнес төвийн 1004 тоот<br>■ Утас: 99167457, 86267888, 77111101<br>■ javkhlantord@gmail.com |

“Жавхлант орд” ХХК нь 2008 онд байгуулагдсан ба Зангат-Уул-1 нэртэй 9444Х тоот хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайг Саусгоби Сэндс ХХК-аас 2009 онд шилжүүлэн авч 2010-2011 онд өөрийн хөрөнгөөр ордын баруун хэсэгт геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэн баттай, бодитой, боломжтой (А+В+С) зэргээр нийт 18.09 сая.тн нүүрсний нөөцийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, 2011.11.18-ны өдөр АМГ-ын КХ-ын даргын тушаалаар MV-016952 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан. Улмаар 2015-2017 онд ордын зүүн хэсэгт хайгуулын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж бодитой болон боломжтой (В+С) зэргээр 10.23 сая.тн нүүрсний нөөцийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан. Ийнхүү ордын нийт геологийн нөөц 28.32 сая.тн (ордын баруун хэсгийн геологийн нөөц 18.09 сая.тн, зүүн хэсгийн геологийн нөөц 10.23 сая.тн) болж уурхай нь жилд 1.5 сая.тн нүүрс олборлох хүчин чадалтайгаар төслийн ТЭЗҮ-д тусгагдсан байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөлд нийт 29,100.14 га талбай хамаарагдана.

2012 онд жилд 740 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтай анхны ТЭЗҮ боловсруулсан байдаг ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг 2012, 2018 онуудад тус тус боловсруулан үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд компанийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, уурхайн хүчин чадлыг 1.5 сая.тн нүүрс олборлохоор төлөвлөн Гоулдэн Прожект ХХК-ийн ТЭЗҮ-г шинэчилсэн.

Зангат-Уулын чулуун нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт Улаанбаатар хотоос баруун урд зүгт 980км, Даланзадгад сумаас баруун урд зүгт 300 км, Гурвантэс сумын хойд зүгт 25 км-т оршдог.

Уг уурхай нь 2024 онд 3 сараар эхэлж уурхайн олборлолт эхэлж, 205386 м³ нүүрс, 1358668 м³ хөрс хуулж, 1564054 м³ уулын цулыг олборлосон байна. Нийт 60-150 хүн ажилласан.

**1.1 Төслийн байршил**

“Жавхлант орд” ХХК-ийн эзэмшдэг MV-016952 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Зангат-Уулын чулуун нүүрсний орд нь засаг захиргааны хувьд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт харьяалагддаг ба Улаанбаатар хотоос 960 км, Даланзадгад хотоос 300 км, Гурвантэс сумын төвөөс 27 км зайд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 2-р багийн нутагт байрладаг.


- Талбайн хэмжээ: 29100.14га

**Газарзүйн солбицол**

Хүснэгт 1 Төслийн талбайн эргэлтийн цэгийн солбицол

| №  | Уртгар |    |       | Өргөрөг |    |       |
|----|--------|----|-------|---------|----|-------|
|    | Xd     | Xm | Xs.s  | Yd      | Ym | Ys.s  |
| 1  | 101    | 17 | 56.95 | 43      | 21 | 1.31  |
| 2  | 101    | 14 | 41    | 43      | 21 | 1.31  |
| 3  | 101    | 14 | 41    | 43      | 19 | 46    |
| 4  | 101    | 11 | 46    | 43      | 19 | 46    |
| 5  | 101    | 11 | 46    | 43      | 21 | 1.31  |
| 6  | 101    | 7  | 46    | 43      | 21 | 1.31  |
| 7  | 101    | 7  | 46    | 43      | 15 | 28    |
| 8  | 101    | 15 | 56    | 43      | 15 | 28    |
| 9  | 101    | 15 | 56    | 43      | 13 | 45    |
| 10 | 101    | 14 | 9.17  | 43      | 13 | 45    |
| 11 | 101    | 14 | 9.17  | 43      | 13 | 1.3   |
| 12 | 101    | 19 | 0.68  | 43      | 13 | 1.3   |
| 13 | 101    | 19 | 0.68  | 43      | 14 | 1.3   |
| 14 | 101    | 19 | 0.68  | 43      | 14 | 55.28 |
| 15 | 101    | 22 | 33.66 | 43      | 14 | 55.28 |
| 16 | 101    | 22 | 33.66 | 43      | 15 | 48.46 |
| 17 | 101    | 29 | 25.25 | 43      | 15 | 48.46 |
| 18 | 101    | 29 | 25.25 | 43      | 20 | 33.56 |
| 19 | 101    | 22 | 25.89 | 43      | 20 | 33.56 |
| 20 | 101    | 22 | 25.89 | 43      | 19 | 46    |
| 21 | 101    | 17 | 56.95 | 43      | 19 | 46    |

Зураг № 1 Төслийн талбайн байршил



## 1.2 Төслийн хүчин чадал, ажлын горим

Уурхай нь жилийн 347 хоног тасралтгүй ажиллаж , жилд 1.5 сая.тн нүүрс олборлох хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Орд ашиглалтын хугацаанд нийт 75.76 сая.м<sup>3</sup> хөрс хуулж, 6.4 сая.тн нүүрс олборлоно. Ордын байгаа район нь ус ихтэй гэж таамаглаж байгаа бөгөөд олборлолтын үед уснаас хамгаалах, ус таталтын технологийг сонгож ажиллаж байна.

Газрын гадаргуу нь бага зэрэг налуу ч олборлолтын явцад ямарваа нэгэн хүндрэл үүсэхгүй. Мөн ордын талбайгаар цас борооны ус, урсдаг жалга байрладаг учир олборлолтын явцад гадаргын уснаас хамгаалах суваг, шуудуу татах шаардлагатай.


Хөрсний эзлэхүүн жин - 2.5 тн/м<sup>3</sup>

Нүүрсний эзлэхүүн жин (орд баруун хэсэг) - 1.56 тн/м<sup>3</sup>

Нүүрсний эзлэхүүн жин (орд зүүн хэсэг) - 1.49 тн/м<sup>3</sup>

Хөрсний чулуулгийн бат бэхийн коэффициент Профессор М.М.Продотьяконовын ангиллаар  $\Gamma=3-7$  байна.

Зангат-Уулын ордын баруун хэсэг нь 45-70 градусын уналтай газрын гадаргуугаас 400 метр бол зүүн хэсэг нь 37-50 градусын уналтай газрын гадаргуугаас 270 метрийн гүнд тус тус сунаж тогтдог. Тус ордын нүүрсний биетийн геологийн тогтцын үзүүлэлтүүдээс хамааруулан ордыг гадаад овоолготой авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглаж байна.



Зураг № 2 Төслийн талбайн байршил-2

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ЭРЧИМ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

Ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулах үед байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, тэр нь эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх эсэхийг болон нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэдэг билээ.

Энэ арга нь ашигт малтмал олборлох уурхайн ашиглалтын үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг бөгөөд хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"- ээр тэмдэглэдэг.

"Жавхлант орд" ХХК нь ил аргаар нүүрс олборлох Зангат уул ил уурхайн төсөл хэрэгжсэнээр байгаль орчны төлөв байдал, экологи, орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар гүйцэтгэж хүснэгт №-2-д үзүүлэв.

“Жавхлант Орд” ХХК-ний Зангат уул нүүрсний орд ашиглах төслөөс орчны төлөв байдал, бүс нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, түүний эрчимшил зэргийг магадлан жагсааж, болзошгүй нөлөөллийг тодрууллаа.

### 2.1 Төсөл хэрэгжих үеийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Сөрөг нөлөөллийн эрчим Эдгээр болзошгүй нөлөөллүүдийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал

| Байгаль орчны үзүүлэлт             | Шууд             | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
|------------------------------------|------------------|----------|---------------------|------------------|---------------|----------------|--------------------|--------|------------|------------|
| Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт   |                  |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Газрын доорх урсацын өөрчлөлт      | х                |          |                     |                  | х             |                | х                  |        | х          |            |
| Газрын доорх усны чанарын өөрчлөлт | х                |          |                     |                  | х             |                | х                  |        | х          |            |
| Гадаргын усны урсацын өөрлөлт      | Нөлөөлөл байхгүй |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт          | х                |          | х                   |                  |               |                | х                  | х      |            |            |
| Хөрсний элэгдэл, эвдрэл            | х                |          |                     |                  | х             |                | х                  | х      |            |            |
| Геологийн тогтоцын өөрчлөлт        | х                |          |                     |                  | х             |                | х                  | х      |            |            |
| Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт  |                  | х        |                     | х                |               |                | х                  |        | х          |            |
| Уур амьсгалын (бичил) өөрчлөлт     |                  | х        |                     | х                |               |                | х                  | х      |            |            |
| Байгалийн нөөц, ашиглалт           |                  |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Газрын гадаргын нөөц баялаг        | х                |          |                     |                  | х             |                | х                  |        | х          |            |
| Бэлчээрийн байдал                  | х                |          |                     | х                |               |                | х                  |        | х          |            |
| Эрдэс түүхий эдийн нөөц            | х                |          |                     |                  | х             |                | х                  |        | х          |            |
| Эрчим хүчний нөөц                  | Нөлөөлөл байхгүй |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Байгаль, орчны өөрчлөлт            |                  |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Ундны усны чанар, хэмжээ           | х                |          |                     |                  | х             |                | х                  | х      |            |            |

|                                                                                     |                  |   |   |    |    |   |    |    |    |   |
|-------------------------------------------------------------------------------------|------------------|---|---|----|----|---|----|----|----|---|
| Агаарын бохирдол                                                                    | х                |   | х |    |    | х |    | х  |    |   |
| Хөрсний эвдрэл, бохирдол                                                            | х                |   |   |    | х  |   | х  | х  |    |   |
| Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх                                       |                  | х |   |    | х  | х |    |    |    | х |
| Дуу чимээ, шуугианы нөлөө                                                           | х                |   |   | х  |    |   | х  |    | х  |   |
| Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл                                      |                  |   |   |    |    |   |    |    |    |   |
| Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх                                           | х                |   |   |    | х  |   | х  | х  |    |   |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх                                                  | х                |   |   |    | х  |   | х  | х  |    |   |
| Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх                                          | Нөлөөлөл байхгүй |   |   |    |    |   |    |    |    |   |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх                                                 | Нөлөөлөл байхгүй |   |   |    |    |   |    |    |    |   |
| Археологи, палентологийн олдворт нөлөөлөх                                           | Нөлөөлөл байхгүй |   |   |    |    |   |    |    |    |   |
| Нийгэмд үзүүлэх нөлөө                                                               |                  |   |   |    |    |   |    |    |    |   |
| Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх                                      |                  | х |   | х  |    |   | х  |    |    | х |
| Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх                                                 | х                |   |   | х  |    |   | х  |    | х  |   |
| Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх                                                      |                  | х |   | х  |    | х |    |    |    | х |
| Эдийн засаг, байгаль орчин                                                          |                  |   |   |    |    |   |    |    |    |   |
| Татварын орлого өөрчлөгдөх                                                          | х                |   |   | х  |    |   | х  |    | х  |   |
| Бүс нутгийн орлого нэмэгдэх                                                         | х                |   |   | х  |    |   | х  |    | х  |   |
| Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох                                                  | х                |   |   | х  |    |   | х  |    | х  |   |
| Ажлын байр нэмэгдэх                                                                 | х                |   |   | х  |    |   | х  |    | х  |   |
| Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх                                            | х                |   |   | х  |    |   | х  |    | х  |   |
| 7. Бусад нөлөөлөл                                                                   |                  |   |   |    |    |   |    |    |    |   |
| Уурхайн болон ахуйн бохир уснаас хөрс, ус бохирдох                                  | х                |   |   |    | х  |   | х  |    | х  |   |
| Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх | х                |   |   |    | х  |   | х  | х  |    |   |
| Дүн                                                                                 | 22               | 5 | 2 | 12 | 13 | 3 | 24 | 10 | 14 | 3 |
| Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх                                            | х                |   |   | х  |    |   | х  |    | х  |   |
| 7. Бусад нөлөөлөл                                                                   |                  |   |   |    |    |   |    |    |    |   |
| Уурхайн болон ахуйн бохир уснаас хөрс, ус бохирдох                                  | х                |   |   |    | х  |   | х  |    | х  |   |
| Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх | х                |   |   |    | х  |   | х  | х  |    |   |
| Дүн                                                                                 | 22               | 5 | 2 | 12 | 13 | 3 | 24 | 10 | 14 | 3 |

**Шууд нөлөөлөл**

Болзошгүй нөлөөллийн 22 (81,5%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Нүүрсний орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, бэлчээрийн нөөц багасах, газрын доорх усны чанарт, геологийн тогтоц, ландшафтын хэлбэр,

хүрээлэн буй орчин, тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс зэрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

### **Шууд бус нөлөөлөл**

Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 5 (18,5%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, Уур амьсгалын (бичил) өөрчлөлт, Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх, Үйлчилгээний салбар зэрэгт шууд бусаар нөлөөлөхөөр байна.

### **Өөрөө зохицуулагдах нөлөөлөл**

Нүүрсний орд ашиглах төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 2 (7,4%) нь өөрөө зохицуулагдах нөлөөлөлд хамрагдаж байна.

### **Богино хугацааны нөлөөлөл**

Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 12 (44,4 %) нь богино хугацааны нөлөөлөлд орж байна. Богино хугацааны нөлөөлөлд зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, уур амьсгалын (бичил) өөрчлөлт, бэлчээрийн байдал зэрэг богино хугацаанд өөрөө зохицуулагдах нөлөөлөл гэж авч үзлээ.

### **Урт хугацааны нөлөөлөл**

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн 13 (48,1%) нь урт хугацааны нөлөөлөл бөгөөд төслийн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийн ихэнхи нь урт хугацааны нөлөөлөлд хамрагдаж байна.

### **Нөлөөллийн эрчим**

Төсөл хэрэгжих орчны байгаль орчинд тухайн төслөөс гарах хүчтэй нөлөөлөл их бөгөөд талбайн болон түүний орчны хөрс, ургамлын элэгдэл, байгалийн анхдагч төрх өөрчлөгдөх, агаар, хөрс, усны бохирдол, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх зэрэг нөлөөллүүд байна. Дунд зэргийн эрчимтэй нөлөөлөлд газрын гадаргын нөөц баялаг, зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, татварын орлого, бүс нутгийн орлого нэмэгдэх зэрэг нөлөөллүүд багтана.

Бага зэргийн эрчимтэй нөлөөлөлд хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг нөлөөллүүд багтаж байна. Нийт 27 нөлөөллөөс 10 хүчтэй, 14 дунд зэргийн, 3 бага зэргийн нөлөөлөл байна.

## **2.2 Төслийн талбай орчмын уур амьсгалын нөхцлийн суурь мэдээлэл**

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт өвс ургамалтай, ургамалгүй гадарга, баян бүрд, булаг шанд, уул нуруу, хотгор, хөндий, тэгш тал, говь цөл хослон оршдог нь уур амьсгалын өвөрмөц нөхцөлийг бүрдүүлнэ.

Зангат уулын нүүрсний орд орчмын нутаг дэвсгэр нь цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө цас багатай, хүйтний эрч бага, хавар хүйтэвтэр, шороон шуурга элбэгтэй, салхины чиглэл тогтворгүй, зундаа хуурай халуун уур амьсгалтай. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл -15°C-аас -20°C хүйтэрч, зун +30°C -аас +35°C заримдаа +40°C-аас давж хална. 1 сард агаарын дундаж температур -15°C -аас -18°C, 7-р сард агаарын дундаж температур +20°C-аас +25°C. Жилийн агаарын дундаж температур +2°C-аас +5°C байна. Жилийн дунджаар авч үзвэл салхигүй өдрийн тоо 10-15 хоног.

Хамгийн их салхи хавар тохиолдох бөгөөд дунджаар 5.9 м/сек, хамгийн бага салхитай улирал нь өвөл бөгөөд салхины хурд дунджаар 4.2-4.3 м/сек ба жилийн 30-35 хоног 15 м/сек хүртэл хүчтэй цасан болон шороон шуургатай байдаг.

**Агаарын температур :** Гурвантэс сумын нутагт жилийн агаарын дундаж температур 5.6°C байдаг. Энэ район нь говь цөлийн ширүүн уур амьсгалтай. Өвөл нь 15-20°C хүйтэн, зун, намрын саруудад маш халуун болж агаарын температур +(3°-35°C), зарим үед +40°C хүрдэг.

Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур  $-23^{\circ}\text{C}$ , хамгийн их халуун 8 дугаар сард агаарын дундаж температур  $+30^{\circ}\text{C}$  орчим, агаарын үнэмлэхүй хамгийн их температур  $+39.8^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй бага температур  $-40^{\circ}\text{C}$  байдаг. Гурвантэс сумын цаг уурын станцын мэдээгээр  $+30^{\circ}\text{C}$ -аас халуун өдрийн тоо жилд дунджаар 31 байна.

**Хур тунадас:** Тус бүс нутагт хур тунадасны уналт их биш, жилийн дундаж хур тунадас 82.4 мм, үүний 60 хувь нь зуны улиралд ордог байна. Гурвантэс сум нь уур амьсгалын нэн хуурай дулаан говь, цөлийн бүсэд багтана. Нэн хуурай дулаан говь, цөлийн бүсийн уур амьсгалын ерөнхий онцлог нь агаар, хөрсний чийгээр дутмаг байдаг. Хур тунадас маш бага унадаг, ялангуяа 1970-аад оноос хойш тунадасны хэмжээ улам багасаж зун, намрын саруудад гандуу байдаг болсон. Өвөл цасны бүрхүүлийн зузаан 0-3 мм, зун нь хур тунадасны хэмжээ 30-60 мм, жилд дунджаар 51 мм орчим тунадас унадаг болсон байна.

**Агаарын даралт:** Олон жилийн агаарын хоногийн дундаж даралт 849.2-862 мм м.у.б., 3 дугаар сард 857.5-875.6 мм м.у.б -д хүрч харьцангуй чийгшлийн дундаж 40-49 % болдог байна.

**Нарны гэрэл:** Нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа жилд 2900 орчим цаг, үүнээс дулааны улиралд 1960 цаг байна. Бүс нутгийн хэмжээнд үүл, хур тунадас багатай, нарны гэрлийн эрчим хүч ихтэй юм.

**Салхины горим:** Зангат уулын нүүрсний орд орчмын салхины горим уулсын хоорондын хөндийд бий болсон агаарын даралтын өөрчлөлтөөр циркуляци байдалтай уулын хөндийн салхи үүснэ. Салхины жилийн дундаж хурд 2.0-2.7 м/сек; хамгийн их хурд 14 - 30 м/сек -д хүрдэг. Өвөлдөө баруун, өмнөд зүгийн салхи зундаа баруун, баруун хойд зүгийн салхи зонхилдог нь тус газар нутгийн геологийн тогтоцтой холбоотой. Харин 4 дүгээр сарын салхины дундаж хурд 4.0 м/с хүрдэг байна. Салхигүй үеийн давтагдал өвөл 12-1 сард 52.5-62.6% байдаг бол 4 дүгээр сард энэ нь 31.3% хүртэл буурдаг. Энэ сард өдрийн 13 цагийн салхигүй үеийн давтагдал дөнгөж 9.6% байна. Иймд хаврын улиралд өдрийн цагт их төлөв салхитай байдаг бөгөөд 13 цагийн салхины дундаж хурд 4 дүгээр сард 4 м/сек орчим байна. 4, 5 дугаар саруудад хүчтэй салхи 10-15 удаа тохиолдоно. Жилд дунджаар 25 өдөр шороон шуургатай байдаг. 4, 5 дугаар саруудад 3-4 удаа шороон шуурга болдог.

**Хөрсний гадаргын температур:** Энэ нутагт хөрсний гадаргын жилийн дундаж температур  $9.2^{\circ}\text{C}$ , дулааны улиралд хөрсний гадаргын температур дунджаар  $+25^{\circ}\text{C}$  байдаг бөгөөд 7 дугаар сард  $+34^{\circ}\text{C}$  байна. Гэхдээ зуны халуун өдөр хөрсний гадарга маш их халах тохиолдол байдаг. Хөрсний гадаргын жилийн үнэмлэхүй их температур  $62^{\circ}\text{C}$ . Хөрсний хөлдөлтийн хэм 0.8-1.8 м байдаг.

**Цасан бүрхүүл, цастай өдрийн тоо:** Цасан бүрхүүлийн зузаан дунджаар 2-3 см-ээс хэтэрдэггүй, цасан бүрхүүлийн үнэмлэхүй зузаан нь 16 см байдаг. Жилд цасан бүрхүүлтэй өдрийн тоо 33 байдаг бөгөөд хүйтний улиралд сард 1-3 удаа цас ордог байна. Цас орой унаж (12-р сарын сүүлч, 1-р сарын эхээр) хавар эрт (2-р сарын сүүлчээр) хайлна. Бороотой өдрийн тоо жилд дунджаар 22 байдаг.

### 2.3 Агаарын чанар

Агаарын бохирдолт гэдэг нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүссэн хорт хий, тоос болон бусад бодисын нөлөөгөөр агаарын чанарын хүлцэх хэмжээнд гарсан өөрчлөлт юм.

Зангат уулын чулуун нүүрсний уурхайн технологийн үйл ажиллагааны явцад агаар орчныг бохирдуулж байгаа гол сөрөг нөлөөлөл нь хөрс хуулалт, нүүрс тээвэрлэлт, ачих буулгах процесс. өрөмдлөг тэсэлгээнээс гарах тоосжилт, дуу чимээ юм, Мөн тээврийн хэрэгслийн дотоод шаталтаас үүсэх хорт хий, утаа ялгарна.

Тоосжилт нь гадаад овоолго болон эвдэрсэн газраас ихээр үүсэх ба 1тн шорооноос 50 гр тоосонцор гардаг.

Хүснэгт 2 Шатахууны зарцуулалтаар ялгарах хорт бодисын хэмжээ

| № | Хорт бодис                 | Шатахууны төрөл |                  |
|---|----------------------------|-----------------|------------------|
|   |                            | Бензин г/кг     | Дизель түлш г/кг |
| 1 | Нүүрстөрөгчийн давхар исэл | 225             | 20-30            |
| 2 | Азотын давхар исэл         | 55              | 20-40            |
| 3 | Нүүрстөрөгч                | 20              | 4-10             |
| 4 | Хүхэрлэг хий               | 1.5-2.02        | 10-30            |
| 5 | Хөө тортог                 | 1-1.5           | 3-5              |
| 6 | Хартугалга                 | 0.5-0.85        | -                |
| 7 | Бензин-пирон               | 0.23            | 0.31             |
| 8 | Альдегид                   | 0.8-1.0         | 0.8-1.0          |

**Төслийн агаарт нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ.**

**Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:**

- Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлнэ.
- Нүүрс хадгалах талбайгаас босох тоосны тархалтыг нарийвчлан гаргах БОННУ-нд заагдсан цэгүүдэд байнгын мониторинг хийх

**Бууруулах арга хэмжээ:**

- Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг услах, чийглэх, замыг дагтаршуулах.
- Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулах.
- Хэрэглэгдэхээ больсон хуучин зам болон түр замын хөрсийг сэргээн ургамал байгалийн аясаар ургах нөхцлийг бүрдүүлэх.
- Тэсэлгээ явуулах үеийн салхины хурд, чиглэлийн мэдээг тогтмол авч, салхины хурд ихтэй үед тэсэлгээний ажил хийхийг хориглох.

## 2.4 Гадаргын ус суурь мэдээлэл

Лицензийн талбайн зүүн хэсэгт сайр дагуу дээш задгай булаг байх ба дээрх булаг тухайн орчинд Ноёны формацын шаварлаг заливролит гадаргад ойртож байгаа бүсэд газар доорх алсын урсац хуримтлагдан илэрч байгаа саадын төрлийн дөрөвдөгчийн хурдаст агуулагдах хөрсний ус сайрын дагуу ул чулуулагт тулах замаар хур борооны дараа даац үүсэх уст цэг нь тухайн жил, улиралын уаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим хувьсамтгай сайр садаргын шүүрлийн булаг юм. Баруун болон зүүн талбайн хоорондын завсрыг бүс, лицензийн талбайн зүүн талаас гадагш ус байхгүй.

Зангат уул ордын орчимд байнгын урсгалтай урсгал ус байхгүй учраас гадаргын усанд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл үндсэндээ байхгүй. Харин уурхайн шүүрлийн усыг зайлууснаас усны түвшин буурна.

Төслийн үйл ажиллагааны үед ахуйн бохир ус, хатуу хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн, шатах тослох материал ил задгай хаяж алдагдсанаас хур борооны усаар утаагдан гүний усны чанарт шууд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хүснэгт 3 Лицензийн талбай болон түүний орчмын худаг уст цэгийн бүртгэл

| №                                   | Худгийн нэр     | Координат |    |       |     |    |       | Өндөр<br>шил<br>/м/ | Худгийн<br>гүн, м | Усны<br>тогтсон<br>түвшин |
|-------------------------------------|-----------------|-----------|----|-------|-----|----|-------|---------------------|-------------------|---------------------------|
|                                     |                 | Xd        | Xm | Xs    | Yd  | Ym | Ys    |                     |                   |                           |
| Инженерийн хийцтэй гар худаг        |                 |           |    |       |     |    |       |                     |                   |                           |
| 1                                   | Шаваг ус        | 43        | 17 | 30.48 | 101 | 18 | 38.34 | 1466                | 10                | 6.5                       |
| 2                                   | Улаан худаг     | 43        | 13 | 55.51 | 101 | 20 | 16.53 | 1685                | 8.25              | 6.07                      |
| 3                                   | Ганжир          | 43        | 14 | 49.73 | 101 | 27 | 57.37 | 1673                | 11.6              | 4.34                      |
| 4                                   | Шар хад         | 43        | 17 | 57.50 | 101 | 26 | 28.96 | 1530                | 7.9               | 2.35                      |
| 5                                   | Дунд довцог     | 43        | 17 | 45.71 | 101 | 21 | 8.87  | 1474                | 9.5               | 3.04                      |
| Малчдын гаргасан гар худаг          |                 |           |    |       |     |    |       |                     |                   |                           |
| 1                                   | Далан товч      | 43        | 17 | 30.18 | 101 | 18 | 1.1   | 1464                | 1.74              | 0.89                      |
| 2                                   | Цалгайн буудал  | 43        | 15 | 38.59 | 101 | 15 | 39.27 | 1605                | 3.7               | 1.2                       |
| 3                                   | Муу ус          | 43        | 15 | 47.03 | 101 | 15 | 17.82 | 1598                | 2.6               | 1.92                      |
| 4                                   | Шанд            | 43        | 14 | 0.43  | 101 | 22 | 40.24 | 1673                | 1.64              | 0.37                      |
| 5                                   | Элстэйн худаг   | 43        | 18 | 37.36 | 101 | 29 | 45.8  | 1538                | 1.24              | 0.39                      |
| 6                                   | худаг элс       | 43        | 18 | 16.37 | 101 | 27 | 15.35 | 1525                | 1.37              | 0.31                      |
| 7                                   | Баруун довцог   | 43        | 17 | 29.36 | 101 | 20 | 7.55  | 1473                | 2.4               | 0.3                       |
| 8                                   | Довцог зүүн     | 43        | 17 | 52.21 | 101 | 21 | 44.82 | 1477                | 1.24              | 0.7                       |
| 9                                   | Баянтолгой      | 43        | 18 | 43.61 | 101 | 22 | 52.67 | 1456                | 2                 | 0.58                      |
| Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг |                 |           |    |       |     |    |       |                     |                   |                           |
| 1                                   | Машбатын худаг  | 43        | 21 | 10.89 | 101 | 25 | 48.43 | 1404                | 78.9              | 3.03                      |
| 2                                   | Унд ахуйн худаг | 43        | 17 | 42.94 | 101 | 21 | 58.48 | 1488                | 32                | 21.7                      |

Хүснэгт 4 Лицензийн талбайн гаднах задгай булаг уст цэг

| Д/Д | Булгийн нэр   | Координат |    |       |     |    |       | Ө н д ө р ш | Булгийн төрөл                                            |
|-----|---------------|-----------|----|-------|-----|----|-------|-------------|----------------------------------------------------------|
|     |               | Xd        | Xm | Xs    | Yd  | Ym | Ys    |             |                                                          |
| 1   | Элст задгай   | 43        | 18 | 39.55 | 101 | 29 | 44    | 1535        | Сайр садрга шүүрлийн /<br>хур тунадасаар<br>тэжээгддэг / |
| 2   | Сүүж булаг    | 43        | 14 | 4.54  | 101 | 24 | 9.19  | 1673        | Шаварлаг хөрс /<br>үндсэн ундаргатай /                   |
| 3   | Довын булаг   | 43        | 14 | 1.19  | 101 | 21 | 9.59  | 1672        | Шаварлаг хөрс / үндсэн<br>ундаргатай /                   |
| 4   | Эхэн задгай   | 43        | 13 | 45.63 | 101 | 17 | 25.94 | 1698        | Шаварлаг хөрс / үндсэн<br>ундаргатай /                   |
| 5   | Адгийн задгай | 43        | 13 | 55.24 | 101 | 17 | 24.4  | 1996        | Шаварлаг / үндсэн<br>ундаргатай /                        |
| 6   | Ямаан ус      | 43        | 14 | 13.61 | 101 | 14 | 21.42 | 1791        | Ан цав / шүүрлийн/                                       |

Төслийн гадаргын болон газрын доорхи усанд нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ.

- Нүүрсний ордыг ашиглах үйл ажиллагааны үед газрын доорхи усны шинж, химийн найрлагын өөрчлөлтийг судлахын тулд мониторингийн судалгааг хийх.
- Усны хэрэглээнд хяналт тавьж, хэрэглэсэн усны балансыг гаргаж байх.

- Үйл ажиллагаа явуулах үед машин техник, тоног төхөөрөмжийн элэгдсэн эд анги, хөдөлгүүрийн шингэн, шатахуун, тос маслын хаягдал ба тээвэрлэлтээс үүсэх хорт бодис, шороо тоосны ялгаралт нь ус бохирдуулахаас сэргийлэх.
- Ахуйн болон технологийн бохир усаар газрын доорх ус бохирдохоос сэргийлэх.
- Унд ахуйн усны эх үүсвэрийн ариун цэврийн хамгаалалтын бүсэд мөрдөх журам гарган мөрдөж ажиллах.
- Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч усны чанар, нөөцөд хяналт тавьж ажиллах.
- Ажилчдын кемп болон үйлдвэрлэлийн ажлын үед гарах ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжид нийлүүлэх
- Бохир усны цэвэрлэгээ хийхдээ цэвэршилтийн зэргийг хянах зорилгоор усанд хими, бактериологийн шинжилгээг тогтмол хийж байх, бохир ус зөөвөрлөх явцад сумын мэргэжлийн байгууллагын зөвшөөрлөөр зориулалтын машинаар гүйцэтгэх, цэвэрлэх байгууламжид нийлүүлэх.
- Орчны хяналт шинжилгээний хүрээнд тухайн байгууллага нь санал нэгтэй хүлээн зөвшөөрөхүйц үр дүнд хүрэх зорилгоор олон нийтийн оролцоотой усны хяналт шинжилгээ хийх (Уснаас дээж авах зэрэгт).
- Усны дээж авахдаа MNS ISO 5667-1-2002, MNS ISO 5667-3-1999, MNS ISO 5667-4-2001, MNS ISO 5667-10-2001 стандартын арга аргачлалын дагуу авч гүйцэтгэх.

## 2.5 Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчийн суурь мэдээлэл

Төслийн талбайн нь хөрс газар зүйн мужлалт, био-уур амьсгалын хувьд Говийн их мужийн өргөрөгийн бүсчлэлд хамаарах заримдаг цөлийн цайвар бор хөрсний дээд бүс Манлайн 11-р тойрогт хамрагдах ба хөрмсний морфлоги, хими, физик шинж чанарын хүрээнд дараах байдлаар ангилана.

Үүнд:

- Цөлийн бор саарал
- Цөлийн сайр чулуурхаг цөлийн бор
- Элсэн хучаастай бор

Лицензийн талбайн газрын гадаргуу ихэнхдээ урдаасаа хойшоо болон хойноосоо урагш чиглэлтэй бага зэргийн налуу байх ба янз бүрийн гүнтэй өргөн нарийн сайраар хэрчигдсэн харилцан адилгүй түвшинтэй хэвийн долгиорхлог тал зонхилох бөгөөд урд талаараа Хөшөө уул 2225м түүний салбар бэсрэг уулсаар хад чулуун тогтоцтой уулын хойд талруугаа намсан бэлэрхэгжинэ. Талбайн зүүн талд төв хэсэг рүү түрж орсон сунасан тогтоцтой хоорондоо салангид хадархаг нам уулс оршино. Хөрсний ихэнх хэсгийг Бор сараал өнгөтэй бөөрөнхий самранцар бүтэцтэй үндэс бага тархсан нүх сүвэрхэг, нягт жижиг чулуу, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй карбонажсан үе давхарга бүхий бүрэлдэхүүнээр илэрнэ.

Талбайн хэмжээнд говийн хялгана, хазаар өвс, хүмүүл, баглуур, бударгана, хотир, хармаг зэрэг бутлаг ургамал зонхилхоос гадна ургамалгүй цулгүй газар нэлээд талбай өртнө.

### **Шууд нөлөөлөл:**

Уурхайн ашиглалтын хугацаанд байгалийн ландшафтын унаган төрх алдагдаж 5000 м урттай, 3000 м өргөнтэй, 60 м гүнтэй хоосон орон зай үүснэ.

2023 оны байдлаар уурхайн ашиглалтын үйл ажиллагааны улмаас 55.8 га талбай элэгдэл, эвдрэлд өртсөн бөгөөд 2024 онд уурхайн олборлолтонд 164.3 га талбай өртөнө.

Хөрс хуулалтаас гарсан шимт хөрс удаан хадгалах явцад шимт, шимэрхэг чанараа

алдана. Мөн хөрс хуулалт, нүүрс олборлолтын (тэсэлгээ, малталт, ачилт зэрэг) үйл ажиллагааны явцад нарийн шороо, нунтаг нүүрс их дэгдэнэ.

Ялангуяа хүнд оврын техникээр шимт давхаргын шороо, гадаад овоолгын шороо ачих, тээвэрлэх, буулгах ойрын зайны олон удаагийн тээвэрлэлтийн үед хөрс нь их халцайн нунтгарснаас орчны хөрс, ургамал нь нарийн шороо, тоосонд дарагдаж доройтолд оруулна. Техник тоног тохөөрөмжийн засвар үйлчилгээнээс гарсан ШТМ-алдагдсанаас хөрс хүнд металаар бохирдож болзошгүй.

#### ***Урьдчилан сэргийлэх арга хэмжээ***

- Хөрсний мониторингийн цэгүүдэд тогтмол хугацаанд хэмжилт хийж байх.
- Нягтаршиж бохирдсон талбайг тэгшлэн сийрэгжүүлж ургамалжуулах.

#### ***Бууруулах арга хэмжээ***

- Хуурай халуун улиралд овоолгын дээрх том машин механизмийн замын усалгааны хугацааг ойртуулах, машин механизмын хурдны хязгаарыг багасгах.
- Ямар ч газар шорооны үйл ажиллагаа эхлэхээс өмнө эвдэгдэх, хөндөгдөх хөрсийг өндөрлөг, налуу хажуу хэсэгт өнгөн хэсгийн давхаргийг тусад авч хадгалах, биологийн нөхөн сэргээлтэндээ ашиглах.
- Хөрс бохирдуулж болзошгүй хог хаягдлыг ангилж ялгах, хөрсөнд алдагдахааргүй хадгалах. Хөрс бохирдуулахааргүй хадгалах газраа тохижуулах (цемент, төмөр гадаргатай байх), орчиндоо тараахгүй байх талаар арга хэмжээ авах (хашаа хаалт барих) гэх мэт арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Хог хаягдлыг ангилал, шинж чанараас нь хамааран (Шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэж зөвшөөрөгдсөн газарт хаях, булах, ариутгах ажлыг хийж байх, гадны нөлөөлөлөөс тусад нь байлгах, амьтан, ургамал нөлөөлөхөөргүй нөхцөлд байршуулах), (Хатуу хог хаягдлыг хадгалах цэг байгуулан түүнд төвлөрүүлэн хаяж байх, Хатуу хог хаягдлын цэг нь зориулалтын тагтай байх, салхи шуургатай үед хог хаягдал хийсч орчноо бохирдуулахгүй байх ёстой) түүнд таарсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Уурхай орчим, доторх зам талбайг тодорхой зам-нэгдсэн нэг зам ашиглах талд дээр анхаарах. Тухайлбал: Замын тэмдэг тэмдэглэгээг сайтар байршуулах, зам ашиглах тал дээр уурхайн зүгээс хатуу бодлогыг баримтлах нь хөрсөн бүрхэвч эвдрэх эрсдэлээс сэргийлж чадна.
- Уурхай орчмын зогсоол, замд машин техникийн шатах тослох материал асгарвал тухай бүрд нь элс, даавуу зэрэгт шингээн авч галын аюулгүй нөхцөлд ариутгах.
- Төрөл бүрийн бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалтанд сайтар анхааралаа хандуулах. Химийн бодис бусад бүтээгдэхүүн хөрсийг бохирдуулах, хөрсний шинж чанарыг доройтуулах олон төрлийн химийн бодис байдаг бөгөөд бүтээгдэхүүний баглаа боодолын бүрэн бүтэн байдлыг сайтар шалгах, хадгалах газрын битүүмжлэлийг сайтар бүрдүүлэх
- Халуун хуурай улиралд уурхайн үйл ажиллагааны явцад хөрсний гадаргаас авто машин, техникийн хөдөлгөөнөөс үүдэлтэй, мөн уурхайн карьерын эвдэгдсэн гадаргуугаас тоосжилт бий болох нь даамжиггүй бөгөөд тоосжилтыг багасгахын тулд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлбэл зохилтой:
- Машин техникийн хөдөлгөөний хурдыг хөрсний гадаргын шинж чанараас хамааруулан тогтоох. Тухайлбал тоосжилт их гарч буй гадаргад хурдны хэмжээг багасгах.

- Тоосжилт их үүсэж буй гадаргууд тодорхой хугацаанд услагаа хийх, Их салхи шуургатай тохиолдолд машин техникийн хөдөлгөөнийг хязгаарлах.
- Жижиг оврын цэвэршүүлэх технологийг түр суурингын ус хэрэглээнд авч хэрэгжүүлэх нь бохир усаар хөрс, үл хөрсний ус бохирдох эрсдэлээс сэргийлнэ.

## 2.5 Ургамлан нөмрөгийн суурь мэдээлэл

Төслийн талбайн нь 1375-1544 д.т.д метрийн өндөрт хэдбэлзэх ба өндөр уул нурууд байхгүй говийн бэсрэг уулсын толгод гүвээрхэг гадарга бүхий /аараг толгод/ ландшафт зонхилно. Ургамал зүйн хувьд Говь-Алтайн тойрогт хамаарах ба шар модот хотир, бариулт бүйлэс, ахар навчит баглуур, говийн хялгана, сайрын хялгана, Гялгар дэрс, Хөмөл, Цагаан лууль, прижвальскийн зээргэнэ, хазаар өвс, сибирь шарилж, өлчир шарилж, ишгэн шаваг, зэрэг тохиолдоно. Уурхайн орчимд унаган ургамал байхгүй, ургамлын бүрхэцийн хувьд нэгж талбайд 10-20% бүрхэцтэй арви нь сийрэг ургалын бүрхэцтэй болно. Уурхайн орчимд 18 овогийн 28 төрлийн 30 зүйл ургамал бүртгэгдсэн байна.

Хүснэгт 5 Ургамлын зүйлийн бүрдэл

[illegible]

|             |                                                                                       |   |   |   |   |   |    |   |   |   |   |   |  |
|-------------|---------------------------------------------------------------------------------------|---|---|---|---|---|----|---|---|---|---|---|--|
| 1           | <i>Iris tenuifolia</i> Pall.-Нарийн цахилдаг                                          |   |   |   |   |   |    | * | * |   | * |   |  |
| <b>VII</b>  | <b>Polygonaceae Juss. - Тарнын овог</b>                                               |   |   |   |   |   |    |   |   |   |   |   |  |
| 1           | <i>Rheum nanum</i> Slievers.-<br>Намхан гишүүнэ                                       |   |   |   |   |   |    |   | * |   | * |   |  |
| 2           | <i>Calligonum gobicum</i><br>Bge.ex Meisn.-Говийн азар                                |   | * |   |   |   |    | * | * |   |   | * |  |
| <b>VIII</b> | <b>Chenopodiaceae Vent. - Луулийн овог</b>                                            |   |   |   |   |   |    |   |   |   |   |   |  |
| 1           | <i>Chenopodium glaucum</i> L.- Хөх ногоон лууль                                       |   |   |   |   |   |    |   | * | * |   |   |  |
| 2           | <i>Eurotia ceratoides</i> (L.)<br>С.А.Мей-Орог тэсэг                                  |   |   |   |   |   |    |   | * |   | * |   |  |
| 3           | <i>Bassia dasyphylla</i> (Fisch.et Mey.)<br>Ktze.- Үслиг манан-хамхаг                 |   |   |   |   |   |    |   | * | * |   |   |  |
| 4           | <i>Corispermum mongolicum</i><br>Ilgin-Монгол хамхуул                                 |   |   |   | * |   |    |   | * | * |   |   |  |
| 5           | <i>Salsola passerina</i> Bge.-Бор бударгана                                           |   |   |   | * |   |    |   |   |   |   | * |  |
| 6           | <i>Salsola collina</i> Pall.-<br>Толгодын бударгана                                   |   |   |   |   |   |    |   | * | * |   |   |  |
| 7           | <i>Anabasis brevifolia</i><br>С.А.Мей.-Ахар навчит баглуур                            |   |   |   |   |   |    |   | * |   |   | * |  |
| <b>IX</b>   | <b>Brassicaceae Juss. -Тоонолжин цэцэгтэний овог</b>                                  |   |   |   |   |   |    |   |   |   |   |   |  |
| 1           | <i>Ptilotrichum tenuifolium</i> (Steph.)<br>С.А.Мей.-Нарийн навчит янгиц              |   |   |   |   |   |    |   | * |   |   | * |  |
| 2           | <i>Dontostemon perennis</i> C. A. Mey<br>- Олон наст багдай, зөөлөн,<br>муригар үстэй |   |   | * |   |   |    | * | * |   | * |   |  |
| <b>X</b>    | <b>Rosaceae Juss. -Сарнайн овог</b>                                                   |   |   |   |   |   |    |   |   |   |   |   |  |
| 1           | <i>Amygdalus pedunculata</i><br>Pall.-Барилт бүйлээс                                  |   |   |   |   |   |    | * | * |   |   | * |  |
| <b>XI</b>   | <b>Fadaceae Juss. - Буурцагтаны овог</b>                                              |   |   |   |   |   |    |   |   |   |   |   |  |
| 1           | <i>Caragana leucophloea</i><br>Pojark. - Алтан харгана                                |   |   |   |   |   |    | * | * |   |   | * |  |
